



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/187

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Худалдаан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай 02 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 8,936,775 (найман сая есөн зуун гучин зургаан мянга долоон зуун далан тав) төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бигэр сумын Мянгайн талбайн 100 га газрыг хашаалж, хамгаалалтыг сайжруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулан, хэрэгжүүлэх эрхийг Бигэр сумын Засаг дарга (Г.Мөнхбаяр)-д шилжүүлсүгэй.

2.Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Бигэр сумын Засаг дарга (Г.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

C:\Documents\ ZDA4

8233310151

